

БАТЛАВ.

ТМЗН-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Ц.БОЛОРМАА



**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН
БҮХ ГИШҮҮДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“СПОРТЛОГ ТМЗ-2024” СПОРТЫН VI НААДМЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

1.1. Монгол Улсад Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний /цаашид ТМЗҮ гэх/ тогтолцоо үүсэж хөгжсөний 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах “СПОРТЛОГ ТМЗ-2024” спортын VI их наадмын зорилго нь татварын мэргэшсэн зөвлөхүүд /цаашид ТМЗ гэх/-ийг идэвхжүүлэх, ахмад ба залуу үеийн холбоог сайжруулж, гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлэхэд оршино.

Хоёр. Хамрагдах хүрээ, тэмцээний төрөл, хугацаа,

2.1. Хамрагдах хүрээ:

2.1.1 Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээдүүд

2.1.2 Татварын мэргэшсэн зөвлөхүүд

2.2. Тэмцээний төрөл:

| № | Төрөл | Огноо | Хугацаа | Болох газар |
|---|--------------------|----------------------------|--------------|--|
| 1 | Дартс | 05 сарын 24 өдөр | 08:00 цаг | Модны 2 /Шинэ-Од ширээний теннисний клуб/ |
| 2 | Ширээний теннис | | 08:00 цаг | |
| 3 | Шатар | | 17:00 цаг | ТМЗН-ийн байранд |
| 4 | Волейбол | 05 сарын 25, 26 өдөр | 08:00 цаг | Хан-Уул дүүрэг, 21-р хороо Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль (ҮБТДС) /Буянт-Ухаа спорт цогцолбороос урагш 2,2км-т байрлана/ |
| 5 | Сагсан бөмбөг | | | |

2.2. Хугацаа: Спортын VI наадам 2024 он 5 дугаар сарын 24 - 26-ны өдрүүдэд

2.2.1 Нээлтийн үйл ажиллагаа: 2024 оны 5-р сарын 25-ны өдрийн 12:00 цагт болно.

2.2.2 **Хаалтын үйл ажиллагаа:** 2024 оны 5-р сарын 26-ны өдөр тэмцээний хамгийн сүүлийн тоглолт дууссаны дараа болно.

Гурав. Тэмцээний зохион байгуулалт

- 3.1. Тэмцээний техникийн зөвлөгөөнд зохион байгуулагчид болон багийн ахлагч, шүүгчид оролцож тэмцээнтэй холбоотой асуудлыг хэлэлцэн зөвшилцөнө. Үүнд:
- 3.1.1 **Техникийн зөвлөгөөн I:** 2024 оны 5-р сарын 6-ны өдрийн 12:00 цагт Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн байранд болно. Тус техникийн зөвлөгөөнөөр тэмцээний удирдамж, оролцох багийн бүрэлдэхүүн, тэмцээн зохион байгуулах газрын мэдээлэл болон бусад асуудлыг хэлэлцэн тохиролцож, шийдвэрлэнэ. Техникийн зөвлөгөөнд ерөнхий шүүгч оролцох шаардлагагүй.
- 3.1.2 **Техникийн зөвлөгөөн II:** 2024 оны 5-р сарын 20-ны өдрийн 12:00 цагт Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн байранд болно. Техникийн зөвлөгөөнөөр тэмцээнд оролцох багуудын жагсаалтыг эцэслэн зарлаж, багуудыг сугалаагаар хэсэгт хувааж, тэмцээний дүрэм, дэгийг танилцуулна.
- 3.2. Багийн ахлагч нар тэмцээнд оролцогч баг, тамирчдын мэдүүлгийг үнэн зөв гүйцэд бөглөж 2024 оны 5-р сарын 20-ны өдрийн 12:00 цагаас өмнө info@cpta.mn и-мэйл хаягаар урьдчилан техникийн зөвлөлд ирүүлсэн байна. /Мэдүүлгийн загварыг хавсаргав./
- 3.3. Тэмцээнд оролцох багууд хэсэгт хуваагдсанаас хойш тэмцээнд өөр багийг нэмж оролцуулахгүй.

Дөрөв. Багийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

- 4.1. Тэмцээнд оролцох багууд Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэгийн гишүүдээр багаа бүрдүүлнэ. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нэгдэн оролцож болох бөгөөд ТМЗ-ийн эрхтэй гишүүдээр багаа бүрдүүлсэн байвал зохино. Хэрэв ТМЗ-ийн эрхтэй гишүүдийн тоо хүрэлцэхгүй, баг бүрдэхгүй тохиолдолд баг бүрдүүлэхтэй холбоотой асуудлаа техникийн зөвлөгөөний эхний хуралдаанд урьдчилан танилцуулж шийдвэрлүүлэх бөгөөд хуралдаанаас гарсан шийдвэр эцсийн байна.
- 4.2. Тэмцээнд:
- 4.2.1 Сагсан бөмбөг эрэгтэй 8 тамирчин;
- 4.2.2 Сагсан бөмбөг эмэгтэй 8 тамирчин;
- 4.2.3 Волейбол эрэгтэй 9 тамирчин;
- 4.2.4 Волейбол эмэгтэй 9 тамирчин;
- 4.2.5 Шатар 3 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин;
- 4.2.6 Ширээний теннис 2 эрэгтэй, 3 эмэгтэй тамирчин;
- 4.2.7 Дартс 3 эрэгтэй, 3 эмэгтэй тамирчид тус тус оролцоно.
- 4.3. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд тэмцээнд баг бүрдүүлэхдээ:
- 4.3.1 Сагсан бөмбөг талбай дээр 3-аас доошгүй ТМЗ гишүүн заавал байх;
- 4.3.2 Волейбол талбай дээр 4-өөс доошгүй ТМЗ гишүүн заавал байх ;
- 4.3.3 Шатар 3-аас доошгүй ТМЗ гишүүн заавал оролцох;
- 4.3.4 Ширээний теннис 3-аас доошгүй ТМЗ гишүүн заавал оролцох;

- 4.3.5 Дартс 3-аас доошгүй ТМЗ гишүүн заавал оролцох.
- 4.3.6 Тамирчин тухайн байгууллагийн үндсэн ажилтан байх ба 6 сараас доошгүй хугацаанд НДШ төлж, И-монголиа баталгаажсан байх.
- 4.4. Баг тус бүр нь тоглолтын цайвар өнгийн нэг, тод ялгарах бараан өнгийн нэг, ар өвөрт нь тамирчдын хувийн дугаарыг бичүүлсэн ижил өнгийн өмсгөлтэйгөөр тоглолтод оролцоно.
- 4.5. Тэмцээний талбайд гарсан багуудын хувцасны өнгө ижил эсвэл төстэй байх тохиолдолд талбайн эзэн буюу тоглолтын хуваарьт зүүн гарт бичигдсэн баг тоглолтын өөр өнгийн нөөц хувцсаа сольж өмсөнө.
- 4.6. Тоглох цагтаа тухайн баг байгаагүй тохиолдолд эсрэг багийг хожсоноор тооцно.
- 4.7. Тэмцээнд оролцогч баг энэ удирдамжид заасан журмыг зөрчсөний улмаас тэмцээнээс хасагдсан тохиолдолд тэмцээнд оролцох эрхийн төлбөрийг буцаан олгохгүй.
- 4.8. Тэмцээнтэй холбогдон гарч болох маргаантай асуудлыг багийн ахлагчаар дамжуулан зохион байгуулагчид болон ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.
- 4.9. Салбар, хуулийн этгээд ТМЗ гишүүдээр багаа бүрдүүлж болно.
- 4.10. Тамирчин давхар багт бүртгэлтэй байх, өөр багийн өмнөөс тоглолтонд оролцохыг хориглоно.

Тав. Тэмцээний санхүүжилт

- 5.1. Оролцогч баг тус бүрээс тэмцээнд оролцох эрхийн хураамж авна.
- 5.2. Эрхийн хураамж:

| № | Спортын төрөл | Нэг бүрт оролцох эрхийн төлбөр | | Бүх төрөлд оролцох эрхийн төлбөр |
|---|---------------|--------------------------------|------------|----------------------------------|
| | | Эр | Эм | |
| 1 | Сагсан бөмбөг | 350,000.00 | 350,000.00 | 2,000,000.00 |
| 2 | Гар бөмбөг | 350,000.00 | 350,000.00 | |
| 3 | Дартс | 300,000.00 | | |
| 4 | Теннис | 300,000.00 | | |
| 5 | Шатар | 300,000.00 | | |

- 5.3. Техникийн зөвлөгөөн II хуралдахаас өмнө багууд эрхийн хураамжаа өгсөн байна. Хэрэв техникийн зөвлөгөөн II хуралдахаас өмнө эрхийн хураамжаа төлөөгүй бол тэмцээний сугалаанд оролцуулахгүй болно.
- 5.4. Баг тус бүр болон бусад этгээдүүд тэмцээний шагнал, зохион байгуулалтад зориулан мөнгөн дэмжлэг үзүүлж болно.
- 5.5. Хамтран ажиллах, ивээн тэтгэгч хувь хүн, хуулийн этгээдүүдийн дэмжлэг

Зургаа. Шагнал, урамшуулал

- 6.1. Тэмцээний төрөл тус бүрээр эхний 3-н байр эзлүүлж, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал гардуулна.
- 6.2. Багийн нийлбэр дүнгээр:
- 6.2.1 Нэгдүгээр байр -Шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 6.2.2 Хоёрдугаар байр- Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 6.2.3 Гуравдугаар байр-Өргөмжлөл, мөнгөн шагнал.

6.3. Идэвхтэй оролцсон багийн хөгжөөн дэмжигчдийг олон нийтийн идэвхийн оноогоор урамшуулна.

6.4. Багийн нийт оноо: Зөвхөн бүх төрөлд оролцсон багуудын оноог дүгнэнэ. Нийлбэр дүнг бага онооны системээр дүгнэж гаргана.

САНААЧЛАГЧ: ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН
НИЙГЭМЛЭГИЙН АЖЛЫН АЛБА
ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ажлын хэсэг:

| | |
|--|---------------|
| Баянзүрх салбарыг төлөөлж ТМЗ | Д.Амарбат |
| Хан-Уул салбарыг төлөөлж ТМЗ | Б.Цэрэндолгор |
| “Монголтакс ТМЗ” ХХК-ийг төлөөлж | Т.Пүрэвжав |
| Сүхбаатар салбар, Хууль эрх зүйн менежментийн хороог төлөөлж ТМЗ | П.Дашдаваа |
| Сонгинохайрхан салбарыг төлөөлж ТМЗ | В.Нарантуяа |
| Ажлын албыг төлөөлж | |
| ТМЗН-ийн мэдээлэл технологийн инженер | Ү.Ганболд |
| ТМЗН-ийн гишүүд салбар хариуцсан менежер | Э.Бадамтуяа |

ТМЗН-ийн салбарын менежерүүд

| | | |
|----------------------------------|--------------|----------|
| Хан-Уул салбарын менежер: | Ц.Саранчимэг | 89128822 |
| Баянзүрх салбарын дарга: | Д.Амарбат | 99009881 |
| Баянгол салбарын дарга: | Г.Гантуул | 91904848 |
| Чингэлтэй салбарын менежер: | П.Арвинбаяр | 99979834 |
| Сүхбаатар салбарын менежер: | Ө.Болормаа | 99049424 |
| Сонгинохайрхан салбарын менежер: | Б.Энхцэцэг | 80111909 |

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН БҮХ ГИШҮҮДИЙН
“СПОРТЛОГ ТМЗ-2024” СПОРТЫН VI НААДМЫН БАГИЙН МЭДҮҮЛЭГ**

Тэмцээний төрөл:

Харьяалал:

Багийн нэр:

Багийн ахлагч:

| Д/д | Зураг | Тоглогчийн овог, нэр | ТМЗ гишүүний дугаар | Хүйс | Ажлын газар | Спортын зэрэг, цол |
|-----|-------|-------------------------|------------------------|------|----------------|-----------------------|
| 1 | | | | | | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| 4 | | | | | | |
| 5 | | | | | | |
| 6 | | | | | | |

Мэдүүлэг бичсэн багийн ахлагч:

Утасны дугаар: